



**ARAM**  
Annual Reporting Award of Mongolia

**ШИЛДЭГ ТАЙЛАН ШАЛГАРУУЛАХ  
ҮНДЭСНИЙ УРАЛДААН**

2016 оны 10 дугаар сарын 14-ны өдөр

Улаанбаатар хот

## **“УЛААНБААТАР БҮК” ХК-д**

2015 оны жилийн “Шилдэг тайлан шалгаруулах үндэсний уралдаан”-ы шүүгчид, зөвлөхүүдээс танай жилийн тайлангийн үнэлгээний талаар дараах тайлбар, зөвлөмжийг хүргүүлж байна.

### **ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

- Компаний санхүүгийн болон санхүүгийн бус тайлан мэдээллийг сонирхогч этгээд саадгүй хүлээн авах мэдээллийн эх сурвалжийг бүрдүүлэх.
- Компаний вэб хуудсанд 2015 оны жилийн тайланг байршуулах
- Компаний жилийн тайлангийн хэвлэлтийн дизайн, стандартыг анхаарч ажиллах
- Жилийн тайланг англи хэл рүү бүрэн хөрвүүлэн хэвлэх

### **СТРАТЕГИ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ**

- Компаний үндсэн үйл ажиллагаа болон ТУЗ, гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүнд орсон аливаа өөрчлөлтийг мэдээлэх, хэрэв өөрчлөлт ороогүй бол энэ тухай тайланд дурдах
- Байгууллагын стратеги зорилгыг хангах ерөнхий схемийг дүрсэлсэн нь бусад компаниудын тайлантай харьцуулахад давуу талтай байв. Харин стратеги зорилтуудыг аль болох хэмжигдэхүйц үр дүнтэй байхаар томьёолж, тухайн зорилтыг биелүүлэхэд шаардагдах хүний нөөцийн бүтцийг тодорхойлох
- Компаний үйл ажиллагаанд нөлөөлөх макро эдийн засаг, салбарын эрсдлийг томьёолсон боловч эдгээр нь хэт ерөнхий тодорхойлогдсон байна. Тухайн төрлийн эрсдлүүд нь ямар сувгаар дамжиж компаний үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлдөг болон нөлөөлөх магадлалыг тайлбарлах

### **САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ**

- Санал, зөвлөмж байхгүй

### **ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАГНАЛ**

- Гүйцэтгэх удирдлагыг хэрхэн сонгодог, гүйцэтгэх удирдлагын цалин хөлсний бодлого зэргийг дэлгэрэнгүй тайлбарлах

- ТУЗ-н дэргэдэх хороодын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, тухайн хороодод ажилладаг гишүүдийн оролцоо, хэлэлцсэн асуудлын талаар мэдээлэл оруулах
- Тайланд компаний хувьцаа эзэмшигчдийн бүтэц, шууд болон шууд бус хяналт тавьдаг жинхэнэ эздийн мэдээлэл, хувьцааны үнийн түүхэн мэдээлэл, хэлбэлзэл, түүхэн хугацаанд хуваарилсан ногдол ашиг, ногдол ашгийн бодлогын талаар тусгах
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн болон хийгдээгүй аль ч тохиолдолд дурдаж тайлбарлах

## **ДОТООД ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН ТАЙЛАГНАЛ**

- Компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар дэлгэрэнгүй мэдээлэлийг оруулах
- Тайлант хугацаанд дотоод хяналтаар илэрсэн алдаа дутагдал, эдгээрт авсан арга хэмжээний талаар тайлбарлах. Хэрэв ямар нэгэн алдаа дутагдал гараагүй бол энэ тухайгаа дурдах
- Компанийн өөрийн тодорхойлсон эрсдлүүд нь үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх, нөлөөллийн сувгийг тодорхой баримттайгаар дэлгэрэнгүй тайлбарлах. Эдгээр эрсдлүүд нь өмнөх тайлант хугацаатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдөж байгааг мөн өрсөлдөгч компанитайгаа харьцуулахад ямар байгааг харьцуулах.

## **ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ**

- Компаний гол гол сонирхлын бүлгүүдийг тодорхойлох.
- Компаний үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчин, агаар, хөрсний бохирдол, хог хаягдал зэрэгт ямар нөлөө үзүүлж байгааг хэмжигдэхүйцээр тодорхой баримттай харуулах.